



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

№ 07

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасан асуудлаар  
тусгайлан шийдвэр гаргах тухай

Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалт, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоол, Улсын Дээд шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 001/ХТ2022/01275 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Атар-Өргөө ХК-ийн нийт хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хэмжээний хувьцааг өөрийн нэр дээр бүртгүүлсэн "Таванбогд инвест" ХХК-ийн эзэмшилд буй саналын эрхгүй хувьцааг бусдад худалдахаар санал болгох болон бусад хэлбэрээр шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглосугай.
2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан шийдвэрийн хэргэжилтэнд хяналт тавьж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 23 оны 04 сарын 28 өдөр

№ 08

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай

Хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Атар-Өргөө ХК-ийн Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, дотоод ажлын  
зардлын төсвийг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээ болон дотоод ажлын зардлын төсвийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, дотоод ажлын зардлын төсөв”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

№ 06

Улаанбаатар хот

Компаний 2023 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцээд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хавсралтаар зөвшөөрч, баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж,  
бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн Дүрмийн “Долоо”-ын 7.22 дахь заалт, хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Дор дурдсан хүмүүсийг Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр

1. Бэрэнбарал овогтой Мөнхдалай
2. Бэрэнбарал овогтой Ганбат
3. Жамц овогтой Сайнбилэг
4. Ганзориг овогтой Энхболд
5. Ганзориг овогтой Баттулга
6. Мөнхдалай овогтой Мөнхтэнгис

Хараат бус гишүүнээр

1. Сүхбаатар овогтой Бямбахорлоо
2. Тогоо овогтой Жигмэдагва
3. Пүрэв овогтой Болормаа

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

№ 01

Улаанбаатар хот

Тооллогын комиссын тогтоолыг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын “Хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01, “Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын комиссын дүнгийн тухай” 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тогтоолыг тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 23 оны 04 сарын 28 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ



## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023ны 04сарын 28 өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөх тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдэд “Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн тогтоол)-т хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

“Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/23 тогтоол)-ийг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ